



73 Page



74 Page



75 Page



76 Page



77 Page

Иаков3

-Jacob3-

Тайлбарлагч Төрсөн нутгаасаа гараад 20жил өнгөрчээ. Иаков төрсөн нутгаа маш ихээр санаж байв. Нэгэн өдөр Иаков шийдвэр гарган өөрийн өмч хөрөнгөө таслан авч төрсөн нутгаа зорин явав. Гэртээ ойртох тусам Иаковын санаа нь ихэд зовж байв. Тэр, ах Есаваас маш их айж байлаа.

Иаков "Ах одоо болтол намайг үзэн ядаж байвал яана аа?"

Тайлбарлагч Иаков эхлээд өөрийн зарц нараа ах Есав уруугаа явуулав. Хэсэг хугацааны дараа зарц нар нь Иаков дээр ирээд хэлэв.

Зарц "Есав 400 хүнээ дагуулан тантай уулзахаар ирж байна"

Тайлбарлагч Түүний дамжуулсан үгийг сонсоод ах нь уурлан ирж яваа байх хэмээн Иаков ихэд айж байв.

Тайлбарлагч Иаков эхлээд гэр бүлээ явуулж, мөн зарц нартаа даатган ахдаа бэлэг сэлт бэлдүүлэв. Ах нь, өөрийг нь алчихаж магадгүй гэж бодон тэр хамт явсангүй.

Тайлбарлагч Тэр өдрийнхөө орой Иаков ганцаараа санаа зовон сууж байлаа. Гэнэт хаанаас ч юм нэгэн хүн гараад иржээ. Тэр бол Бурханы илгээсэн тэнгэр элч байв. Иаков Бурхантай шөнөжингөө барилдаж гэнэ. Иаков ялагдахгүйн тулд ноцолдсоор байв. Үүр цайх үед тэнгэр элч ингэж хэлэв.

Тэнгэр элч "Энэ цагаас эхлэн чамайг Израиль гэж дуудах болно."

Тайлбарлагч Тэнгэр элч түүнийг орхин явав. Иаков ахтайгаа уулзахаар очиход ах нь түүний бодсоноос огт эсрэгээр, дүүгээ найрсагаар угтан халуун дотноор тэврэн авчээ.

Есав "Их санасан шүү дүү минь!"

Тайлбарлагч Ингэж олон жилийн дараа ах дүү хоёр уулзжээ. Тэд бие биенээ тэврэн, хамтдаа уйлалдав. Аавынхаа ерөөлийг мөн Бурханы ерөөлийг хүртсэн Иаков их баян хүн болж төрсөн нутагтаа буцан иржээ.